



## НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/404

Улаанбаатар хот

### Автотээврийн хэрэгслийн хорт утаа хэмжих ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 20 дугаар зүйлийн 20.5, Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 19<sup>1</sup> дүгээр зүйлийн 19<sup>1</sup>.3.1, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалт, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10/05 дугаар тогтоолоор батлагдсан “Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 2 дугаар зүйлийн 2.5-3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянгол дүүргийн нутаг дэвсгэр дэх авто замын сүлжээгээр зорчин хөдөлгөөнд оролцож зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү хорт утаа ялгаруулж буй автотээврийн хэрэгсэлд холбогдох “Дизель хөдөлгүүртэй авто машин – Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5014:2009, “Бензин хөдөлгүүртэй авто машин–Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5013:2009) стандартыг мөрдүүлэх, автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт цаг хугацаандаа орсон эсэхийг шалгах ажлыг 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Автотээврийн хэрэгслийн хорт утаа хэмжих ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Хяналт, шалгалтын хугацаанд нийт 1500 автотээврийн хэрэгсэлд үзлэг хийж, 7 хоногийн 3 өдөр хэмжилтийн ажлыг тогтмол зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсэгт, техникийн хяналтын үзлэгт цаг хугацаандаа ороогүй, зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү хорт утаа ялгаруулж байгаа автотээврийн хэрэгсэлд өдөр бүр тогтмол хяналт тавьж авто замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, зөрчлийг арилгуулж ажиллахыг Замын цагдаагийн хэлтэс /цагдаагийн хурандаа Ц.Ариунболд/ олон нийтэд тогтмол сурталчилж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Х.Мөнхзул/-т тус тус даалгасугай.

4. Автотээврийн хэрэгслийн хорт утаа хэмжих ажилд шаардагдах зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргахыг Тамгын газар /Д.Дэлгэрмаа/-д зөвшөөрсүгэй.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган, үр дүнг тогтмол танилцуулахыг Эдийн засаг, худалдаа, үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслийн удирдагч /Э.Батбилэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.ОДОНТУЯА

Баянгол дүүргийн Засаг даргын  
2019 оны 07 дүгээр сарын 09 ны өдрийн  
А/404 дугаар захирамжийн хавсралт



АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХОРТ УТАА ХЭМЖИХ  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Э.Батбилэг	Эдийн засаг, худалдаа үйлчилгээ, тохижилт, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч
Нарийн бичгийн дарга:	М.Галбадрах	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Байгаль орчин, орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Ж.Ганболд	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ц.Ариунболд	Замын цагдаагийн хэлтсийн дарга
	Д.Баттөмөр	Баянгол техникийн хяналтын үзлэгийн төвийн дарга /Зөвшилцсөнөөр/